



**2021 оны Намрын улиралд суралцагчдыг Хамрах хүрээний Үйл явц: Баталсан тухай Мэдэгдэл  
Захидал: Уэйкфилд Ахлах Сургуулийн 9-11 дүгээр ангид суралцагчдын гэр бүлийнхэн**

2021 оны 12 сарын 10

Хүндэт Уэйквилд сургуульд суралцагчдын гэр бүлийнхэн Танаа:

2021 оны 12-р сарын 2-ны өдөр Сургуулийн Удирдах Зөвлөл 2022 оны 8-р сараас хэрэгжүүлж эхлэх 2021 оны Намрын улиралд суралцагчдыг Хамрах хүрээний Өөрчлөлтийг батлан санал хураалаа.

2022-23 оны хичээлийн жилд 46110, 46120, 46111, 48160, 48180, 48290, 46140, 48150, 48280, 48281 төлөвлөлтийн нэгжүүдийн суралцагчдыг Уэйкфилд сургуулиас Вашингтон-Либерти Ахлах Сургууль руу шилжүүлэн суралцуулахаар болсон. Энэхүү өөрчлөлт нь 9-р ангид элсэн орох бүх сурагчид (2021-22 онд 8-р ангид суралцагчид) болон дээр дурдсан төлөвлөлтийн нэгжид оршин сууж буй ахлах ангийн бүх сурагчдад хамаарна. 2021 оны 6-р сарын 17-ноос өмнө Уэйкфилд сургуульд суралцаж байгаа 9-11 дугаар ангийн сурагчид 12-р ангиа тус сургуульд дүүргэх эсвэл шинээр төлөвлөгдсөн зэргэлдээх сургууль (Вашингтон-Либерти Ахлах Сургууль)-д 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн суралцах боломжтой. Уэйкфилд сургуульд үргэлжлүүлэн суралцахыг хүсэгчдэд нэмэлт арга хэмжээ авах шаардлагагүй. **2022-2023 оны хичээлийн жилд сургуулиа өөрчлөн Вашингтон-Либерти Ахлах Сургуульд суралцахыг хүссэн 9-11 дүгээр ангид суралцагчдын гэр бүлийнхэн 2022 оны 1 сарын 27-ны өдөр гэхэд дараахь алхмуудыг хийх хэрэгтэй. Үүнд:**

- 2022-23 оны хичээлийн жилд танай хүүхэд Вашингтон-Либерти Ахлах Сургуульд суралцах болсныг Уэйкфилд сургуулийн Зөвлөлийн Захирлын туслах Рейна Берриостой холбогдон мэдэгдэнэ үү.
- Хатагтай Берриостой [reyna.berrios@apsva.us](mailto:reyna.berrios@apsva.us) цахим шуудангаар эсвэл 703-228-6702 утсаар холбогдоно уу.

**Ах, эгч дүүс болон Тээвэрлэлтийн талаарх Мэдээлэл**

- **Ах, эгч дүүс :** Уэйкфилд сургуулийн 9-11 дүгээр ангийн сурагчдын 8-р ангид суралцдаг дүү нар нь Уэйкфилд сургууль руу шилжин 2022-23 оны хичээлийн жилд ах, эгчийнхээ хамт Уэйкфилд сургуульд элсэн орж суралцах боломжтой. Эдгээр сурагчдын гэр бүл бүрт захидал, маягтуудыг тус тусад нь илгээнэ.
- **Тээвэрлэлт :** Уэйкфилд сургуульд үргэлжлүүлэн суралцах эсвэл Вашингтон-Либерти сргууль (шинээр төлөвлөгдсөн зэргэлдээх сургууль)-д суралцахаар сонгосон эсэхээс үл хамааран зорчих бүсийн гадна амьдардаг дээрх төлөвлөлтийн нэгжийн суралцагчдад АУС тээврийн хэрэгслээр үйлчилнэ. Эдгээр төлөвлөлтийн нэгжид амьдардаг Уэйкфилд сургуульд үргэлжлүүлэн суралцаж байгаа 9-11 дүгээр ангийн сурагчдыг мужийн төвлөрсөн зогсоолоос тээвэрлэх болно.

Хэрэв та бүхэнд тодруулах асуулт байвал [engage@apsva.us](mailto:engage@apsva.us) хаяг руу цахим шуудан илгээх эсвэл Төлөвлөлт, Үнэлгээний албатай 703-228-2481 утсаар холбогдоно уу. 2021 оны Намрын улирлын Хамрах хүрээний Үйл явцын талаарх нэмэлт мэдээллийг <https://www.apsva.us/engage/fall-2021-boundary-process> холбоосоор орж авна уу.

Баярлалаа,

Лиза Стенгл

Төлөвлөлт, Үнэлгээний Албаны Дарга  
Арлингтоны Улсын Сургууль